



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 41 (326)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай*
- *Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны арваннэгдүгээр сарын 5

№ 41 (326)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |   |     |
|------|---|-----|
| 548. | Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай (2003-10-10-ны хууль)                           | 905 |
| 549. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2003-10-16-ны хууль) | 907 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 550. | Улсын Их Хурлын 2003 оны 38 дугаар тогтоолын заалтад тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн тухай | Дугаар 40 | 908 |
|------|---|-----------|-----|

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |   |            |     |
|------|---|------------|-----|
| 551. | Людмила Константиновна Герасимовичийг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 170 | 908 |
| 552. | Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай                                | Дугаар 171 | 908 |
| 553. | Ш. Загдааг шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, томилох тухай              | Дугаар 172 | 908 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

### ДАВС ИОДЖУУЛЖ ИОД ДУТЛААС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүн амын оюуны чадамжийг хамгаалж, иод дутлаас сэргийлэх, хүнсний иоджуулсан давсыг үйлдвэрлэх, хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль тогтоомж

2.1. Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Эрүүл мэндийн тухай хууль<sup>2</sup>, Хүнсний тухай

хууль<sup>3</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "иод дутал"-гэж хүний бие мэхбодид зайлшгүй шаардлагатай иод зохистой хэмжээнд хүрэхгүй байхыг;

3.1.2. "иоджуулсан давс" гэж хүнсний давсыг тусгай технологи, стандартын дагуу иодоор баяжуулсныг.

<sup>1</sup> Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Эрүүл мэндийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Хүнсний тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Иод дутлаас сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалт

#### 4 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

4.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амыг иод дутлаас сэргийлэх, иод дуталтай тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. хүн амыг иод дутлаас сэргийлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.1.2. хүнсний давс болон бусад бүтээгдэхүүнийг иоджуулахад шаардлагатай иодын зохистой хэмжээг тогтоож, үндэсний стандартад тусгах;

4.1.3. иод дутлын эмгэгийн тархалтын судалгаа тандалт, хяналт, үнэлгээ хийх, эмчлэх, сэргийлэх арга хэмжээ авах.

4.2. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амыг иод дутлаас сэргийлэх, иод дуталтай тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.2.1. иоджуулсан давсны үйлдвэрийн тоног төхөөрөмж, баяжуулах бодисын нийлүүлэлт, хангамжийн бодлого боловсруулах;

4.2.2. иоджуулсан давсны үйлдвэрлэл, хангамжийн асуудлаар улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох;

4.2.3. иоджуулсан давсны чанарыг сайжруулах, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх.

#### 5 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

5.1. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нь хүн амыг иод дутлаас сэргийлэх, иод дуталтай тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. иод дутлаас сэргийлэх талаар гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;

5.1.2. нутаг дэвсгэрийнхээ хүн амыг иоджуулсан давсаар хангах, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээд иоджуулсан давс ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих;

5.1.3. нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд иод дутлаас сэргийлэх, иоджуулсан давсыг хэрэглэх талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах.

#### 6 дугаар зүйл. Иргэний эрх, үүрэг

6.1. Давс иоджуулах, борлуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж нь хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд иоджуулсан давс худалдаж, хэрэглэж байгаа эсэхийг иргэн хянах эрхтэй.

6.2. Иргэн иод дутлаас сэргийлэх, иод дуталтай тэмцэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

6.2.1. хүнсэндээ иоджуулсан давс, бусад бүтээгдэхүүнийг хэрэглэх;

6.2.2. иод дутлаас сэргийлэх талаар зохион байгуулж буй арга хэмжээнд оролцох, дэмжих.

#### 7 дугаар зүйл. Иоджуулсан давсны үйлдвэрлэл

7.1. Хүнсний давсыг үйлдвэрлэлийн аргаар, стандартын дагуу иоджуулна.

7.2. Иоджуулсан давсыг үйлдвэрлэх, борлуулах, хэрэглэх, хадгалах шатанд иодын агууламжийг эрх бүхий байгууллага хянана.

7.3. Иоджуулсан давс үйлдвэрлэгч этгээд Хүнсний тухай хуулийн гуравдугаар бүлгийн 8, 9 дүгээр зүйлд заасан эрхийг эдэлж, үүрэг, хариуцлага хүлээнэ.

#### 8 дугаар зүйл. Иоджуулсан давсны импорт, борлуулалт

8.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүнсний иоджуулсан давс борлуулна.

8.2. Хүнсний хэрэглээнд зориулсан, жижиглэн савласан иоджуулсан давс нь стандартад тохирсон шошго бүхий сав, баглаа, боодолтой байна.

8.3. Монгол Улсад хүнсний иоджуулсан давс импортлоно.



8.4. Импортын иоджуулсан давсны иодын агууламж нь улсын стандартын шаардлагад тохирсон байна.

### 9 дүгээр зүйл. Иоджуулсан давсны хэрэглээ

9.1. Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа этгээд хоол, хүнсний бүтээгдэхүүн бэлтгэхдээ иоджуулсан давс хэрэглэнэ.

9.2. Айл өрх хүнсэндээ иоджуулсан давс хэрэглэнэ.

### 10 дугаар зүйл. Иоджуулсан давсны чанарт тавих хяналт

10.1. Давс иоджуулах, борлуулах үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж нь хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн нийтлэг журам, хэм хэмжээ, шаардлагыг хангасан байна.

10.2. Иоджуулсан давсны чанарт тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага Хүнсний тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт заасны дагуу хэрэгжүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

### 11 дүгээр зүйл. Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

11.1. Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрх бүхий улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

11.1.1. энэ хуулийн 7.1-ийг зөрчсөн иргэнийг 8000-15000, албан тушаалтныг 10000-20000, хуулийн этгээдийг 60000-150000 төгрөгөөр торгох;

11.1.2. энэ хуулийн 8.1-ийг зөрчсөн иргэнийг 10000-20000, албан тушаалтныг 20000-30000, хуулийн этгээдийг 150000 хүртэл төгрөгөөр торгох;

11.1.3. энэ хуулийн 8.3, 8.4, 9.1-ийг зөрчсөн иргэнийг 15000-20000, албан тушаалтныг 25000-30000, хуулийн этгээдийг 150000 хүртэл төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 10 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй:

**16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6 дахь заалт:**

“6/замын хөдөлгөөний дүрмээр түр буюу удаан зогсохыг хориглосон замын зорчих хэсэгт зайлшгүй зогсолтоос бусад хэлбэрээр зогсоож, хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийг тусгай хашаа, талбайд шилжүүлэх.

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсний болон тусгай хашаа, талбайд байлгасан хугацааны зардлыг тухайн тээврийн хэрэгслийн жолооч хариуцна.

Зориулалтын чирэгч автомашин ашиглан тээврийн хэрэгслийг зөөж, шилжүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын 2003 оны 38 дугаар тогтоолын заалтад тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 14.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2 дахь заалтад Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

Монгол Улсын Их Хурал 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдөр баталсан Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 38 дугаар тогтоолын

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 10 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

Людмила Константиновна Герасимовичийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монголын утга зохиолыг гадаад орнуудад сурталчлах, монгол судлалыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Санкт-Петербург хотын их сургуулийн ахмад багш Людмила Константиновна Герасимовичийг

"Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 10 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

Шүүхийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 57 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 78 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

татах зөвшөөрөл олгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг нь түдгэлзүүлсүгэй.

Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Чантуугийн Элдэв-Очирыг эрүүгийн хариуцлагад

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 10 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Ш. Загдааг шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, томилох тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1, 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Булган аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

Өөрөө хүсэлт гаргасан Шадийн Загдааг

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 0.5